



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 1/164

Чингис хот

Г Мал сүрэгт үзлэг ангилалт хийж,
цөм сүрэг бүрдүүлэн хээлтүүлэгч шинээр
нөхөн тавих тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.3-ын “а”, 30 дугаар зүйлийн 30.1.16, Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дэх зүйлийн 4.5.1 дэх заалт, Улсын Их Хурлын 2010 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол мал” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал сүрэгт үзлэг ангилалт хийж цөм сүрэг бүрдүүлэх, баталгаажуулах ажлыг удирдан зохион байгуулах бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.
2. Сумдын бөг малын хээлтүүлэгч, цөм сүргээр бүртгэгдсэн мал, ноолуурын чанар, гарц сайтай Галшар сумын улаан ямаа тархсан Баянхутаг, Баянмөнх, Галшар, Дархан сумдын ямаа, Мах-сүүний хосолмол ашиг шимтэй Дадал сумын үхэр, Галшар сумын адуун сүрэгт үзлэг ангилалт хийж цөм сүрэг бүрдүүлэх, баталгаажуулах ажлын хэсгийг байгуулан, хэрэгжилтийг хангуулах, тайлан мэдээг удирдамжид заасан хугацаанд ирүүлэхийг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.
3. Сумдын Мал эмнэлэг үржлийн таса-, мал үржлийн аж ахуйн нэгжийн мал сүрэгт хийсэн үзлэг ангилалтын ажилд хяналт тавьж ажиллахыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар /Ж.Энх-Амгалан/-т, Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/-т тус тус даалгасугай.
4. Мал сүрэгт үзлэг ангилалт хийж цөм сүрэг бүрдүүлэх, баталгаажуулах ажлын нэгдсэн дүнг Улсын мал эмнэлэг, үржлийн газарт хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч аймгийн Засаг даргын орлогч /Ц.Чогсомжав/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБЯМБА



Аймгийн Засаг даргын 2018 оны 04
дугаар сарын 16-өдрийн 16 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

МАЛ СҮРЭГТ ҮЗЛЭГ АНГИЛАЛТ ХИЙЖ
ЦӨМ СҮРЭГ БҮРДҮҮЛЭХ, БАТАЛГААЖУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- | | | |
|-----------------------|---------------|--|
| Ажлын хэсгийн ахлагч: | Ц.Чогсомжав | -Аймгийн Засаг даргын орлогч |
| Гишүүд: | Ж.Энх-Амгалан | -Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга |
| | Б.Мөнхжаргал | -Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого
төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн |
| | Б.Сүнгээ | -Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын
дарга |
| | Г.Гантөмөр | -Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын
Мал аж ахуйн албаны дарга |